



ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН
ХОРШООДЫН
2023 ОНЫ ХОЁРДУГААР
УЛИРЛЫН САНХҮҮГИЙН
ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛИЙН
ТАНИЛЦУУЛГА

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ГАЗАР

УЛААНБААТАР ХОТ

АГУУЛГА

НЭГ.САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ	2
1.1 Зах зээлийн ерөнхий мэдээлэл.....	2
1.2 ХЗХ-дын тархалтын мэдээлэл.....	3
1.3 ХЗХ-дын гишүүдийн мэдээлэл.....	3
1.4 Бодлого, зохицуулалтын орчин.....	5
ХОЁР.НЭГТГЭЛИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТҮҮД	7
2.1 Статистик үзүүлэлтүүд.....	7
2.2 Санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд.....	9
2.2.1 Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд...10	
2.2.2 Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд.....	11
ГУРАВ.НИЙТ ХӨРӨНГИЙН БҮТЭЦ, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА	12
3.1 Хөрөнгийн бүтцийн талаар.....	12
3.2 Хөрөнгийн төвлөрлийн талаар.....	13
3.3 Зээлийн үйл ажиллагааны талаар.....	13
3.4 Зээлийн чанарын талаар.....	14
ДӨРӨВ.НИЙТ ЭХ ҮҮСВЭРИЙН БҮТЭЦ, ХАДГАЛАМЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА	16
4.1 Эх үүсвэрийн бүтцийн талаар.....	16
4.2 Хадгаламжийн үйл ажиллагааны талаар.....	17
4.3 Бусдаас авсан зээл, өр төлбөрийн талаар.....	18
4.4 Бусад богино хугацаат өр төлбөрийн талаар.....	18
4.5 Гишүүдийн оруулсан хувь хөрөнгийн талаар.....	19
4.6 Өөрийн хөрөнгө, хоршоологчдын өмчийн талаар.....	19
ТАВ.ОРЛОГО, ЗАРДАЛ, АШИГТ АЖИЛЛАГАА	20
5.1 ХЗХ-дын орлогын талаар.....	20
5.2 ХЗХ-дын зардлын талаар.....	20
5.3 ХЗХ-дын ашигт ажиллагааны талаар.....	21
ЗУРГАА.ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	22
6.1 ХЗХ-дын шалгуур үзүүлэлтийн талаар.....	22
ДОЛОО.ДҮГНЭЛТ	23

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООДЫН 2023 ОНЫ 2 ДУГААР УЛИРЛЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

2023.08.02


Улаанбаатар хот

НЭГ. САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

1.1 Зах зээлийн ерөнхий мэдээлэл

2023 оны 2 дугаар улирлын байдлаар Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-оос хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон 192 хадгаламж, зээлийн хоршоо (цаашид “ХЗХ” гэх) үйл ажиллагаа явуулж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8 ХЗХ буюу 4.0 хувиар буурсан үзүүлэлт юм. Тайлант улиралд нийт ХЗХ-дын 47.3 хувь буюу 91 ХЗХ орон нутагт, 52.6 хувь буюу 101 ХЗХ Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байна.

График 1: ХЗХ-дын тоо /хот, орон нутгаар/



хангаагүй, өөрийн хөрөнгөгүй болсон, хоршоологчдын өмчгүй болж үйл ажиллагаа нь доголдсон ХЗХ-дын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосонтой холбоотой.

Тайлант улиралд Хорооны хуралдаанаар 1 ХЗХ-нд хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, 1 ХЗХ-ны тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх асуудлыг шийдвэрлэсэн байна. Мөн 26 ХЗХ-ны 215 сонгуульт гишүүн, гүйцэтгэх захирал, нягтлан бодогч, 2 ХЗХ-ны ажлын байрны хаягийн өөрчлөлтийг холбогдох хууль тогтоомжийн дагуу бүртгэсэн байна.

Хүснэгт 1: ХЗХ-дын тусгай зөвшөөрлийн мэдээлэл

Он	2019	2020	2021	2022	2023.И
ХЗХ-дын тоо	261	249	209	196	192
Шинээр олгосон	17	14	-	7	2
Хүчингүй болгосон	35	26	40	20	6
Түдгэлзүүлсэн	10	23	12	13	2
Сэргээсэн	1	6	1	3	-
ТЗ-ийн хугацаа сунгасан	52	49	85	62	-*

*Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуульд 2023.01.06-ны өдөр орсон өөрчлөлтийн дагуу ХЗХ-ны тусгай зөвшөөрөл хугацаагүй болсон.

ХЗХ-дын тоо сүүлийн 5 жилийн хугацаанд тасралтгүй буурсан боловч санхүүгийн болон статистик үзүүлэлтүүд харьцангуй тогтвортой байгаа нь зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг 4 улирал дараалан

1.2 ХЗХ-дын тархалтын мэдээлэл

2023 оны 2 дугаар улирлын байдлаар 192 ХЗХ 61 салбар, 682 ажилтан, 71,184 гишүүн /70,932 иргэн, 252 хуулийн этгээд/-тэйгээр Монгол Улсын 21 аймаг, нийслэлийн 8 дүүрэгт үйл ажиллагаа явуулж байна.

Улаанбаатар хотын 8 дүүрэгт 101 ХЗХ үйл ажиллагаа явуулж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 9 ХЗХ буюу 8.9 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Чингэлтэй, Сүхбаатар, Баянзүрх, Сонгинохайрхан дүүргүүдэд хамгийн их төвлөрөлтэй байна.

Зураг 1: Улаанбаатар хотын ХЗХ-дын тархалт



Орон нутагт Сэлэнгэ аймгаас бусад 20 аймагт 91 ХЗХ үйл ажиллагаа явуулж байна. Баян-Өлгий, Увс, Говь-Алтай, Ховд, Дорнод аймгуудад төвлөрөл их байгаа бол Булган, Говьсүмбэр, Өвөрхангай, Хэнтий аймагт тус бүр 1 ХЗХ үйл ажиллагаа эрхэлж байна.

Зураг 2: ХЗХ-дын тархалт



1.3 ХЗХ-дын гишүүдийн мэдээлэл


2023 оны 2 дугаар улирлын байдлаар ХЗХ-дын нийт гишүүдийн тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1,382 гишүүн буюу 1.9 хувиар буурч 71,184-т хүрсэн үзүүлэлттэй байна. Нийт гишүүдийн 0.4 хувь буюу 252 нь хуулийн этгээд, 53.8 хувь буюу 38,327 нь эмэгтэй гишүүд байна.

Зураг 3: ХЗХ-ны гишүүдийн мэдээлэл



Нийт гишүүдийн 54.4 хувь буюу 38,729 гишүүн Улаанбаатар хотын ХЗХ-нд бүртгэлтэй бол 45.6 хувь буюу 32,455 гишүүн орон нутгийн ХЗХ-нд бүртгэлтэй байна.

График 2: ХЗХ-дын тоо болон гишүүдийн өөрчлөлт /хот, орон нутгаар/



Сүүлийн 5 жилийн хугацаанд ХЗХ-дын тоо буурсан ч 2018-2020 оны 2 дугаар улирлын байдлаар гишүүдийн тоо тогтмол өсч байсан бол 2021 оны 2 дугаар улиралд өмнөх оны мөн үеэс 1.6 хувь, тайлант хугацаанд 1.9 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлдэг ХЗХ-дын гишүүдийн 13.0 хувь буюу 5,022 гишүүн “Бичил бизнесийг дэмжих, ядуурлыг бууруулах нийслэлийн хөтөлбөр”-ийн хүрээнд байгуулагдсан 44 ХЗХ-ны гишүүд байна.

Мөн тайлант улиралд “Ногоон алт-Малын эрүүл мэнд төсөл”-ийн санхүүжилттэй 29 ХЗХ 10,517 гишүүнтэй үйл ажиллагаа явуулсан байна.


Нийт 192 ХЗХ-ны 32.8 хувь буюу 63 ХЗХ 20-100 гишүүнтэй, 51.6 хувь буюу 99 ХЗХ 101-500 гишүүнтэй, 8.9 хувь буюу 17 ХЗХ 501-1,000 гишүүнтэй, 6.8 хувь буюу 13 ХЗХ 1,001-ээс дээш гишүүнтэй байна.

Хүснэгт 2: ХЗХ-ны гишүүнчлэл, интервалаар

Гишүүд /интервалаар/	ХЗХ-ны тоо	Гишүүдийн тоо	Нийт гишүүдэд эзлэх хувь
20-100 гишүүнтэй	63	3,375	4.7%
101-500 гишүүнтэй	99	21,400	30.1%
501-1,000 гишүүнтэй	17	11,419	16.0%
1,001-ээс дээш гишүүнтэй	13	34,990	49.2%
Нийт	192	71,184	100.0%

Гишүүдийн төвлөрлийг хүснэгтээр харуулбал 1,001-ээс дээш гишүүнтэй 13 ХЗХ-ны гишүүд нийт гишүүдийн 49.2 хувийг эзэлж байна.

График 3: ХЗХ-ны гишүүдийн төвлөрөл



1.4 Бодлого, зохицуулалтын орчин

Гадаад харилцаа, хамтын ажиллагаа

- Санхүүгийн зохицуулах хорооны дарга АХБ-ны ТА 9654-MON “Бичил санхүүгийн байгууллагыг чадавхжуулах, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх” төслийн зохицуулагч Женнифер Р.Торрестой 2023 оны 4 дүгээр сарын 09-ний өдөр, төслийн зөвлөхүүдтэй 2023 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр тус тус уулзаж, төслийн явцын талаар санал солилцсон.
- КОЙКА-аас 2025-2028 онуудад хэрэгжүүлэх төслийн саналд хадгаламж, зээлийн хоршооны чиглэлээр хэрэгжүүлэх саналыг 2023 оны 5 дугаар сарын 10-ны өдөр цахимаар хүргүүлсэн.

Хууль, эрх зүйн орчин

- Хадгаламж, зээлийн хоршооны тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төсөл, дагалдах баримт бичгүүдтэй холбоотой асуудлаар МХЗХҮХ-ны Тэргүүлэгчдийн зөвлөлийн гишүүдтэй 2023 оны 4 дүгээр сарын 13-ны өдөр уулзаж, хэлэлцүүлэг зохион байгуулсан.
- ХЗХ-ны салбарт эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоог нэвтрүүлэхээр “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх журам”-ын төслийг боловсруулсан. Журмын төсөл дэх эрсдэлийн үнэлгээний онооны системийг турших зорилгоор 2022 онд тусгай зөвшөөрлийн хугацаа сунгуулсан нэр бүхий 49 ХЗХ-нд зайны үнэлгээний туршилтыг хийж, газар дээрх шалгалтыг Хорооны даргын 2023 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн 184 дүгээр тушаалаар баталсан ажлын хэсэг нэр бүхий 8 ХЗХ-нд 2023 оны 3 дугаар сарын 29-ний өдрөөс 2023 оны 4 дүгээр сарын 04-ний өдрүүдэд туршсан.
- "Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа эрхлэхэд тавих нөхцөл, шаардлага"-ын шинэчилсэн найруулгын

төслийг Хорооны 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 384 дүгээр тогтоолоор батлуулж, ХЗДХЯ-нд бүртгүүлэхээр бүрдэл баримт бичгийн хамт хүргүүлсэн.

- Ажлын албаны даргын 2023 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн А/42 тоот тушаалаар байгуулсан "Бүх нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрт агуулгын шинэчлэл хийхэд холбогдох санал боловсруулах" ажлын хэсэгт газрын төлөөлөл ажилласан.
- Аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүдийн эдийн засаг дахь оролцоог нэмэгдүүлэх тухай хуулийн төслийг байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангах, санал дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг УИХ-ын Нийгмийн бодлогын байнгын хорооны 2023 оны 4 дүгээр сарын 04-ний өдрийн 08 дугаар тогтоолоор байгуулсан бөгөөд ажлын дэд хэсэгт Хорооны төлөөлөл ажиллаж байна.
- Монголбанкны Ерөнхийлөгч, Хорооны даргын 2023 оны 3 дугаар сарын 09-ний өдрийн А-43/108 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, зээлийн хүүгийн хэмжээг бодох, тооцох, хүү, шимтгэл, хураамжийн мэдээллийн ил тод байдлыг хангах аргачлал”-ыг Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу Захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхээр ХЗДХЯ-нд хүргүүлсэн боловч буцаасан тул ажлын хэсгээс шинэчлэн боловсруулсан төсөлд 2023 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр холбогдох саналыг хүргүүлсэн.
- Зөвшөөрлийн цахим системд хадгаламж, зээлийн хоршооны салбарын бүртгэл, зөвшөөрлийн хүсэлтэд бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, маягт болон тусгай зөвшөөрлийн баримт бичгийн бүрдэл

шалгах хуудсыг 2023 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр шинэчлэн байршуулсан.

Хурал, семинар, уулзалт

- АХБ-тай хамтран хэрэгжүүлж буй ТА 9654-MON “Бичил санхүүгийн салбарыг чадавхжуулах, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх” төслийн хүрээнд дотоод хяналтыг сайжруулах, бичил санхүүгийн байгууллагыг чадавхжуулах зорилго бүхий “Хадгаламж зээлийн хоршооны эрсдэлийн удирдлага” сэдэвт сургалтыг 2023 оны 4 дүгээр сарын 26-27-ны өдрүүдэд Баян-Өлгий аймгийн 13 ХЗХ-ны 26 хяналтын зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх захирлыг хамруулан Өлгий суманд зохион байгуулсан. Сургалтаар ХЗХ-ны эрсдэлийг үнэлэх асуулгын хуудас, дотоод хяналтын шалгах хуудсыг хөтөлбөрийн дагуу оролцогчдод танилцуулсан.
- Хорооны 2018 оны 245 дугаар тогтоолоор баталсан “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах нөхцөл, шаардлага”-ын 2.1.12-т заасны дагуу МХЗХҮХ-той хамтран зохион байгуулдаг сургалтад 2023 оны 5 дугаар сарын 19-ний өдөр ХЗХ-дын сонгуульт гишүүн, гүйцэтгэх захирал нийт 50 хүн оролцсон ба Хорооноос "Банкнаас бусад санхүүгийн зах зээлийн тойм" сэдвээр мэдээлэл өгсөн.
- Монголын хуульчдын холбооноос 2023 оны 5 дугаар сарын 01-ний өдөр зохион байгуулсан "Хуульчийн Про Боно өдөр-2023"-т газрын төлөөлөл оролцож иргэдэд хадгаламж, зээлийн хоршооны хууль эрх зүйн орчны талаар мэдээлэл өгсөн.
- Нийслэлийн төсөл хөтөлбөрийн хүрээнд байгуулагдсан хоршоодын зээл төлөлтийн явц, холбогдох асуудлаар “Нийслэлийн жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих төв” НӨҮГ-ын төлөөлөлтэй 2023 оны 5 дугаар сарын 16-ны өдөр уулзаж, санал солилцсон.
- Нийслэлийн удирдах газрын мөрдөн шалгах газрын хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн Мөрдөн байцаах тасаг, Хууль зүй, дотоод хэргийн яам, Санхүүгийн зохицуулах хорооны хамтарсан уулзалтыг 2023 оны 5 дугаар сарын 31-ний өдөр зохион байгуулж Мөнгөн зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор цахим систем, байгууллагуудын мэдээллийн уялдаа холбоог хангах, мэдээллийн санг хэрхэн холбох талаар санал солилцсон.
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газраас зохион байгуулсан "Парисын хэлэлцээр: 6-р бүлэг нүүрстөрөгчийг үнэлэх механизм" зөвлөлдөх уулзалтад 2023 оны 5 дугаар сарын 24-25-ны өдрүүдэд газрын төлөөлөл оролцсон.
- Тогтвортой санхүүжилтийн холбоо (ТоС)-оос зохион байгуулсан "Тогтвортой санхүүжилтийн долоо хоног 2023" сэдэвт хэлэлцүүлэг уулзалтад 2023 оны 6 дугаар сарын 16-ны өдөр газрын төлөөлөл оролцсон.
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор 2023 оны 6 дугаар сарын 14-16-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Тогтвортой санхүүжилтийн 7 хоног 2023” арга хэмжээний хүрээнд “Олон улсын ногоон санхүүгийн манлайллын хөтөлбөр”-т газрын төлөөлөл оролцсон.
- Олон Улсын Хадгаламжийн Даатгагчдын Холбоо (ОУХДХ)-ны 2023 оны 6 дугаар сарын 28-ны өдөр Улаанбаатар хотод зохион байгуулсан Евро-Ази бүсийн хорооны жилийн уулзалтад газрын төлөөлөл оролцсон.

Хугацаагүй хадгаламжийн үлдэгдэл	4,691,253.77	2.3%	4,147,341.72	2.5%	543,912.06	1.3%
Хугацаагүй хадгаламж эзэмшигчийн тоо	4,041	9.7%	3,005	13.9%	1,036	5.2%
Иргэн	4,031	9.7%	2,996	13.8%	1,035	5.2%
Хуулийн этгээд	10	0.0%	9	0.0%	1	0.0%
Хугацаатай хадгаламжийн үлдэгдэл	199,206,503.86	97.7%	158,911,736.14	97.5%	40,294,767.72	98.7%
Хугацаатай хадгаламж эзэмшигчийн тоо	37,553	90.3%	18,685	86.1%	18,868	94.8%
Иргэн	37,495	90.1%	18,673	86.1%	18,822	94.6%
Хуулийн этгээд	58	0.1%	12	0.1%	46	0.2%
Хадгаламж эзэмшигчдийн насжилт	41,526	100.0%	21,669	100.0%	19,857	100.0%
18-35 насны	14,928	35.9%	9,336	43.1%	5,592	28.2%
36-45 насны	10,941	26.4%	5,374	24.8%	5,567	28.0%
46-55 насны	8,903	21.4%	4,039	18.6%	4,864	24.5%
55-аас дээш	6,754	16.3%	2,920	13.5%	3,834	19.3%
Хадгаламж эзэмшигчдийн боловсрол	41,526	100.0%	21,669	100.0%	19,857	100.0%
Дээд	18,979	45.7%	12,939	59.7%	6,040	30.4%
Тусгай дунд	6,106	14.7%	3,089	14.3%	3,017	15.2%
Бүрэн дунд	9,348	22.5%	3,817	17.6%	5,531	27.9%
Дунд	4,258	10.3%	801	3.7%	3,457	17.4%
Бага	2,835	6.8%	1,023	4.7%	1,812	9.1%

2023 оны 2 дугаар улирлын байдлаар ХЗХ-д 41,594 хадгаламж эзэмшигчийн 203,897,757.63 мянган төгрөгийн хадгаламжийг татан төвлөрүүлсэн байна. Нийт хадгаламж эзэмшигчийн 52.1 хувь буюу 21,690 хадгаламж эзэмшигч Улаанбаатар хотын ХЗХ-дын гишүүд ба нийт хадгаламжийн 80.0 хувь буюу 163,059,077.86 мянган төгрөгийг бүрдүүлж байна. Харин 47.9 хувь буюу 18,685 хадгаламж эзэмшигч нь орон нутгийн ХЗХ-дын гишүүд ба нийт хадгаламжийн 20.0 хувь буюу 40,838,679.77 мянган төгрөгийг бүрдүүлж байна.

2.2 Санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд

2023 оны 2 дугаар улирлын байдлаар ХЗХ-ны зах зээлийн нийт хөрөнгө 295,932,583.62 мянган төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 9.0 хувь буюу 24,329,030.05 мянган төгрөгөөр өсөж банкны зах зээлийн 0.6 хувьтай тэнцэж байна.

Тайлант улиралд нийт зээлийн үлдэгдэл 1.2 хувь буюу 2,597,536.41 мянган төгрөгөөр, нийт татан төвлөрүүлсэн хадгаламж 7.7

Нийт хадгаламж эзэмшигчийн 2.3 хувийг хугацаагүй, 97.7 хувийг хугацаатай хадгаламжтай гишүүд эзэлж байна.

Нийт хадгаламж эзэмшигчийн 99.8 хувь буюу 41,526 нь хувь хүн (56.0 хувь буюу 23,264 нь эмэгтэй), 0.2 хувь буюу 68 нь хуулийн этгээд байна.

Нэг хадгаламж эзэмшигчид ногдох дундаж хадгаламж 4,902.10 мянган төгрөг байгаа бөгөөд тус үзүүлэлт Улаанбаатар хотод 7,517.71 мянган төгрөг, орон нутагт 2,051.78 мянган төгрөг байна.

хувь буюу 14,524,458.86 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Зах зээлийн нийт орлого 0.7 хувь буюу 203,421.67 мянган төгрөгөөр, нийт зарлага 9.9 хувь буюу 2,483,767.43 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэнээр нийт цэвэр орлого 45.3 хувь буюу 2,280,345.76 мянган төгрөгөөр буурч 2,753,135.10 мянган төгрөгт хүрсэн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 6: ХЗХ-дын санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд /мянган төгрөгөөр/

Үндсэн үзүүлэлтүүд	2022 оны II улирал	2023 оны II улирал	Өөрчлөлт	
			дүн	хувь
Нийт хөрөнгө	271,603,553.57	295,932,583.62		
Банкны салбарт эзлэх хувь	0.6%	0.6%	24,329,030.05	9.0%
Нийт зээл	217,806,546.33	220,404,082.74		
Банкны салбарт эзлэх хувь	0.9%	0.9%	2,597,536.41	1.2%
Нийт чанаргүй зээл	7,249,010.30	7,269,514.45		
Нийт зээлд чанаргүй зээлийн эзлэх хувь	3.3%	3.3%	20,504.15	0.3%
Банкны салбарт эзлэх хувь	0.3%	0.3%	0.0%	-0.9%
Нийт татан төвлөрүүлсэн хадгаламж	189,373,298.77	203,897,757.63		
Банкны салбарт эзлэх хувь	1.1%	1.1%	14,524,458.86	7.7%
Нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгө	26,070,166.34	27,241,446.91		
Нийт хоршоологчдын өмч	27,247,815.41	34,218,707.94	1,171,280.57	4.5%
Банк, ББСБ, төсөл хөтөлбөрөөс авсан зээл	3,572,483.26	13,734,424.36		
Нийт орлого	30,074,664.38	30,278,086.05	6,970,892.53	25.6%
Нийт зарлага	25,041,183.52	27,524,950.95	10,161,941.10	284.5%
Цэвэр орлого, алдагдал	5,033,480.86	2,753,135.10	-2,280,345.76	-45.3%

2.2.1 Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд

Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй 101 ХЗХ-ны нийт хөрөнгө 234,355,743.80 мянган төгрөг нь зах зээлийн 79.2 хувь, нийт зээл 170,395,559.16 мянган төгрөг нь зах зээлийн 77.3 хувь, нийт хадгаламж 163,059,077.86 мянган төгрөг нь зах зээлийн 86.2 хувийг тус тус бүрдүүлж байна. Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын чанаргүй зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.3 хувь буюу 18,550.01 мянган төгрөгөөр буурч 6,267,964.07 мянган төгрөгт хүрсэн нь нийт зээлийн 3.7 хувийг эзэлж байна. Банк, ББСБ, төсөл хөтөлбөрөөс авсан зээл өмнөх оны мөн үеэс 7.3 хувь буюу 11,052,249.94 мянган төгрөгөөр

нэмэгдсэн байна. Нийт орлого өмнөх оны мөн үеэс 2.1 хувь буюу 472,847.93 мянган төгрөгөөр буурч, нийт зарлага 9.3 хувь буюу 1,779,337.87 мянган төгрөгөөр нэмэгдсэнээр нийт цэвэр орлого 66.4 хувь буюу 2,252,185.79 мянган төгрөгөөр буурч 1,138,101.12 мянган төгрөгт хүрсэн үзүүлэлттэй байна.

Зээлийн мэдээллийн тухай хуульд заасны дагуу Монголбанкнаас ЗМС-ийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл олгосон “Титан Си Ар Эй ЗМС” ХХК, “Бүрэн скор ЗМС” ХХК-тай Улаанбаатар хотын ХЗХ-дын 53.5 хувь буюу 54 ХЗХ мэдээлэл өгөх, авах гэрээ байгуулсан байна.

Хүснэгт 7: Улаанбаатар хотын ХЗХ-дын санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд /мянган төгрөгөөр/

Үндсэн үзүүлэлтүүд	2022 оны II улирал	2023 оны II улирал	Өөрчлөлт	
			дүн	хувь
Нийт хөрөнгө	216,312,844.09	234,355,743.80		
ХЗХ-ны нийт хөрөнгөд эзлэх хувь	79.6%	79.2%	18,042,899.71	8.3%
Нийт зээл	171,157,573.55	170,395,599.16		
ХЗХ-ны нийт зээлд эзлэх хувь	78.6%	77.3%	-761,974.39	-0.4%
Нийт чанаргүй зээл	6,286,514.08	6,267,964.07		
ХЗХ-ны нийт чанаргүй зээлд эзлэх хувь	86.7%	86.2%	-1,338,610.01	-0.3%
Нийт зээлд чанаргүй зээлийн эзлэх хувь	3.7%	3.7%	0.0%	0.2%
Нийт татан төвлөрүүлсэн хадгаламж	152,006,827.92	163,059,077.86		
ХЗХ-ны нийт хадгаламжид эзлэх хувь	80.3%	80.0%	11,052,249.94	7.3%
Нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгө	19,563,325.98	19,977,387.39		
			414,061.41	2.1%

ХЗХ-ны нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгөд эзлэх хувь	75.0%	73.3%	-1.7%	-2.3%
Нийт хоршоологчдын өмч	19,183,747.52	24,602,147.41	5,418,399.89	28.2%
ХЗХ-ны нийт хоршоологчдын өмчид эзлэх хувь	70.4%	71.9%	1.5%	2.1%
Банк, ББСБ, төсөл хөтөлбөрөөс авсан зээл	3,536,383.26	13,594,424.36	10,058,041.10	284.4%
Нийт орлого	22,504,227.01	22,031,379.08	-472,847.93	-2.1%
Нийт зарлага	19,113,940.10	20,893,277.97	1,779,337.87	9.3%
Цэвэр орлого, алдагдал	3,390,286.91	1,138,101.12	-2,252,185.79	-66.4%

2.2.2 Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд

Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй 91 ХЗХ-ны нийт хөрөнгө 61,576,839.83 мянган төгрөг нь зах зээлийн 20.8 хувь, нийт зээлийн үлдэгдэл 50,008,483.58 мянган төгрөг нь зах зээлийн 22.7 хувь, нийт хадгаламж 40,838,679.77 мянган төгрөг нь зах зээлийн 20.0 хувийг тус тус эзэлж байна. Нийт орлого өмнөх оны мөн үеэс 8.9 хувь буюу 676,269.9 мянган төгрөгөөр, нийт зарлага 11.9 хувь буюу 704,429.56 мянган төгрөгөөр тус тус өсч, цэвэр орлого 1.7 хувь

буюу 28,159.97 мянган төгрөгөөр буурч 1,615,033.98 мянган төгрөгт хүрсэн байна.

Зээлийн мэдээллийн тухай хуульд заасны дагуу Монголбанкнаас ЗМС-ийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл олгосон “Титан Си Ар Эй ЗМС” ХХК, “Бүрэн скор ЗМС” ХХК-тай орон нутгийн ХЗХ-дын 48.4 хувь буюу 44 ХЗХ мэдээлэл өгөх, авах гэрээ байгуулсан байна.

Хүснэгт 8: Орон нутгийн ХЗХ-дын санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд /мянган төгрөгөөр/

Үндсэн үзүүлэлтүүд	2022 оны II улирал	2023 оны II улирал	Өөрчлөлт	
			дүн	хувь
Нийт хөрөнгө	55,290,709.48	61,576,839.83	6,286,130.35	11.4%
ХЗХ-ны нийт хөрөнгөд эзлэх хувь	20.4%	20.8%	0.5%	2.2%
Нийт зээл	46,648,972.78	50,008,483.58	3,359,510.80	7.2%
ХЗХ-ны нийт зээлд эзлэх хувь	21.4%	22.7%	1.3%	5.9%
Нийт чанаргүй зээл	962,496.22	1,001,550.38	39,054.16	4.1%
ХЗХ-ны нийт чанаргүй зээлд эзлэх хувь	13.3%	13.8%	0.5%	3.8%
Нийт зээлд чанаргүй зээлийн эзлэх хувь	2.1%	0.6%	-1.5%	-71.5%
Нийт татан төвлөрүүлсэн хадгаламж	37,366,470.85	40,838,679.77	3,472,208.92	9.3%
ХЗХ-ны нийт хадгаламжид эзлэх хувь	19.7%	20.0%	0.3%	1.5%
Нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгө	6,506,840.36	7,264,059.52	757,219.16	11.6%
ХЗХ-ны нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгөд эзлэх хувь	25.0%	26.7%	1.7%	6.8%
Нийт хоршоологчдын өмч	8,064,067.89	9,616,560.53	1,552,492.64	19.3%
ХЗХ-ны нийт хоршоологчдын өмчид эзлэх хувь	29.6%	28.1%	-1.5%	-5.0%
Банк, ББСБ, төсөл хөтөлбөрөөс авсан зээл	36,100.00	140,000.00	103,900.00	287.8%
Нийт орлого	7,570,437.37	8,246,706.96	676,269.59	8.9%
Нийт зарлага	5,927,243.42	6,631,672.98	704,429.56	11.9%
Цэвэр орлого, алдагдал	1,643,193.95	1,615,033.98	-28,159.97	-1.7%

ГУРАВ. НИЙТ ХӨРӨНГИЙН БҮТЭЦ, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

3.1 Хөрөнгийн бүтцийн талаар

Хүснэгт 9: ХЗХ-дын хөрөнгийн бүтэц /мянган төгрөгөөр/

ХӨРӨНГӨ	2022 оны II улирал		2023 оны II улирал		Өөрчлөлт	
	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
Эргэлтийн хөрөнгө	267,695,313.26	98.6%	291,800,966.79	98.6%	24,105,653.53	9.0%
Мөнгөн хөрөнгө	35,233,081.06	13.0%	52,220,645.18	17.7%	16,987,564.11	48.2%
Бэлэн мөнгө	5,336,562.89	2.0%	5,382,160.25	1.8%	45,597.37	0.9%
Банкинд байршуулсан харилцах	7,100,360.98	2.6%	9,659,812.07	3.3%	2,559,451.09	36.0%
Банкинд байршуулсан хадгаламж	22,796,157.20	8.4%	37,178,672.86	12.6%	14,382,515.66	63.1%
Богино хугацаат хөрөнгө оруулалт	220,000.00	0.1%	700,000.00	0.2%	480,000.00	218.2%
Арилжааны үнэт цаас	220,000.00	0.1%	700,000.00	0.2%	480,000.00	218.2%
Зээл /цэврээр/	212,174,169.57	78.1%	215,731,235.92	72.9%	3,557,066.35	1.7%
Нийт зээл	217,806,546.33	80.2%	220,404,082.74	74.5%	2,597,536.41	1.2%
Хэвийн зээл	204,939,114.82	75.5%	205,100,490.80	69.3%	161,375.98	0.1%
Хугацаа хэтэрсэн зээл	5,618,421.20	2.1%	8,034,077.49	2.7%	2,415,656.29	43.0%
Чанаргүй зээл	7,249,010.31	2.7%	7,269,514.45	2.5%	20,504.15	0.3%
(Зээлийн эрсдэлийн сан)	5,632,376.76	2.1%	4,672,846.82	1.6%	-959,529.94	-17.0%
Авллага	17,841,987.37	6.6%	16,663,394.91	5.6%	-1,178,592.46	-6.6%
Байгууллага, хүмүүсээс авах авлага	9,751,542.38	3.6%	7,228,231.56	2.4%	-2,523,310.82	-25.9%
Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	8,090,444.99	3.0%	9,435,163.34	3.2%	1,344,718.36	16.6%
Бусад эргэлтийн хөрөнгө	1,286,158.61	0.5%	5,477,544.44	1.9%	4,191,385.83	325.9%
Өмчлөх бусад хөрөнгө /цэвр/	939,916.65	0.3%	1,008,146.35	0.3%	68,229.70	7.3%
Өмчлөх бусад хөрөнгө	978,229.97	0.3%	1,048,435.40	0.3%	70,205.43	7.2%
(Өмчлөх бусад хөрөнгийн хасагдуулга)	38,313.32	0.0%	40,289.05	0.0%	1,975.73	5.2%
Эргэлтийн бус хөрөнгө	3,908,240.31	1.4%	4,131,616.83	1.4%	223,376.53	5.7%
Үндсэн хөрөнгө /цэвр/	3,666,767.85	1.4%	3,964,031.34	1.3%	297,263.49	8.1%
Үндсэн хөрөнгө	5,831,208.63	2.1%	6,441,666.90	2.2%	610,458.27	10.5%
(Хуримтлагдсан элэгдэл)	2,164,440.78	0.8%	2,477,635.56	0.8%	313,194.78	14.5%
Биет бус хөрөнгө	226,452.46	0.1%	152,032.81	0.1%	-74,419.65	-32.9%
Биет бус хөрөнгө	321,241.68	0.1%	323,145.21	0.1%	1,903.53	0.6%
(Биет бус хөрөнгийн элэгдэл)	94,789.23	0.0%	171,112.40	0.1%	76,323.18	80.5%
Хөрөнгө оруулалт, бусад хөрөнгө	15,020.00	0.0%	15,552.69	0.0%	532.687	3.5%
Хөрөнгө оруулалт, бусад хөрөнгө	15,020.00	0.0%	15,552.69	0.0%	532.687	3.5%
Хөрөнгийн дүн	271,603,553.57	100.0%	295,932,583.62	100.0%	24,329,030.06	9.0%

Зураг 4: Хөрөнгийн зарим үзүүлэлтээс /мянган төгрөгөөр/




2023 оны 2 дугаар улирлын байдлаар ХЗХ-ны зах зээлийн нийт хөрөнгө 295,932,583.62 мянган төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 9.0 хувь буюу 24,329,030.06 мянган төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна. Зах зээлийн нийт хөрөнгийн 98.6 хувийг эргэлтийн хөрөнгө, 1.4 хувийг эргэлтийн бус хөрөнгө бүрдүүлж байгаа бол мөнгөн хөрөнгө нийт хөрөнгийн 17.7 хувийг, цэвр зээл 72.9 хувийг тус тус эзэлж байна.

Нийт зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 1.2 хувь буюу 2,597,536.41 мянган төгрөгөөр буурч 220,404,082.74 мянган төгрөгт хүрсэн бөгөөд 4,672,846.82 мянган төгрөгийн эрсдэлийн сан байгуулж, 215,731,235.92 мянган төгрөгийн цэвэр зээлийн үлдэгдэлтэй байна. Харин хугацаа хэтэрсэн зээл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 43.0 хувь буюу 2,415,656.29 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

ХЗХ-ны зах зээлийн нийт хөрөнгийн өөрчлөлтийг сүүлийн 5 жилээр харьцуулахад 2019 оны 2 дугаар улирлаас тайлант улирал хүртэлх хугацаанд тусгай

зөвшөөрөлтэй ХЗХ-дын тоо тогтмол буурсан ч хөрөнгийн хэмжээ тасралтгүй өссөн үзүүлэлттэй байна.

График 6: ХЗХ-дын тоо болон нийт хөрөнгийн өөрчлөлт /тэрбум төгрөгөөр/




3.2 Хөрөнгийн төвлөрлийн талаар

ХЗХ-дыг хөрөнгийн хэмжээгээр нь ангилахад 10 тэрбум төгрөгөөс дээш хөрөнгөтэй 4 ХЗХ-ны нийт хөрөнгө 177,641,290.35 мянган төгрөг нь зах зээлийн нийт хөрөнгийн 60.0 хувийг, гишүүдийн тоо 19,441 байгаа нь нийт гишүүдийн 27.3 хувийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 10: ХЗХ-дын хөрөнгийн төвлөрөл, интервалаар /мянган төгрөгөөр/

№	Хөрөнгийн хэмжээ	ХЗХ-дын тоо	Нийт хөрөнгө		Гишүүд	
			Дүн	Хувь	Тоо	Хувь
1	10,000,000.0-аас дээш	4	177,641,290.35	60.0%	19,441	27.3%
2	1,000,000.0 -10,000,000.0	29	85,073,417.17	28.7%	25,211	35.4%
3	500,000.0-1,000,000.0	20	13,730,172.05	4.6%	8,076	11.3%
4	100,000.0-500,000.0	71	15,417,367.66	5.2%	12,808	18.0%
5	50,000.0-100,000.0	42	3,250,822.93	1.1%	4,042	5.7%
6	10,000.0-50,000.0	25	818,215.77	0.3%	1,586	2.2%
7	10,000.0 хүртэл	1	1,297.70	0.00%	20	0.0%
Нийт дүн		192	295,932,583.62	100.0%	71,184	100.0%



3.3 Зээлийн үйл ажиллагааны талаар

Тайлант улиралд зах зээл дэх нийт зээлийн үлдэгдэл 220,404,082.74 мянган төгрөг буюу нийт хөрөнгийн 74.5 хувь, цэвэр зээлийн үлдэгдэл 215,731,235.92 мянган төгрөг буюу нийт хөрөнгийн 72.9 хувийг тус тус эзэлж байна.

Зээлийн жигнэсэн дундаж хүү сарын 2.2 хувь, тайлант хугацаанд олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү 2.4 хувь байна.

1 тэрбум төгрөгөөс дээш зээлийн үлдэгдэлтэй 26 ХЗХ-ны зээлийн дүн зах зээлийн нийт зээлийн 85.5 хувийг бүрдүүлж байна. Тайлант улиралд 3 ХЗХ зээлийн үйл ажиллагаа эрхлээгүйгээс 2 ХЗХ 2023 оны 1

дүгээр улирал болон 2023 оны 2 дугаар улиралд шинээр хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан ХЗХ-д байна.

Хүснэгт 11: ХЗХ-дын зээлийн хэмжээ, интервалаар /мянган төгрөгөөр/

№	Зээлийн хэмжээ	ХЗХ-дын тоо	Зээлийн дүн	Эзлэх хувь
1	1,000,000.0 дээш	26	188,497,568.74	85.5%
2	500,000.0-1,000,000.0	18	13,002,831.56	5.9%
3	100,000.0-500,000.0	66	14,819,384.35	6.7%
4	50,000.0-100,000.0	43	3,057,629.85	1.4%
5	10,000.0-50,000.0	35	1,019,579.20	0.5%
6	10,000.0 хүртэл	1	7,089.05	0.0%
7	Зээлийн үйл ажиллагаа эрхлээгүй	3	-	-
Нийт дүн		192	220,404,082.74	100%

3.4 Зээлийн чанарын талаар

Хүснэгт 12: Зээлийн ангиллын мэдээлэл /мянган төгрөгөөр/


Зээлийн ангиллын мэдээлэл	Зээлдэгчийн мэдээлэл		Зээлийн үлдэгдэл	
	Тоо	Хувь	Тоо	Хувь
Нийт	30,257	100.0%	220,404,082.74	100.0%
Хэвийн	27,970	92.4%	205,100,490.80	93.1%
Хугацаа хэтэрсэн	981	3.3%	8,034,077.49	3.6%
Чанаргүй	1,306	4.3%	7,269,514.45	3.3%
<i>Хэвийн бус</i>	<i>378</i>	<i>28.9%</i>	<i>1,918,719.12</i>	<i>26.4%</i>
<i>Эргэлзээтэй</i>	<i>386</i>	<i>29.6%</i>	<i>2,497,981.42</i>	<i>34.4%</i>
<i>Муу</i>	<i>542</i>	<i>41.5%</i>	<i>2,852,813.91</i>	<i>39.2%</i>

2023 оны 2 дугаар улирлын байдлаар ХЗХ-ны зах зээлийн хэмжээнд нийт зээлийн үлдэгдлийн 93.1 хувь буюу 205,100,490.80 мянган төгрөгийг хэвийн зээл, 3.6 хувь буюу 8,034,077.49 мянган төгрөгийг хугацаа хэтэрсэн зээл, 3.3 хувь буюу 7,269,514.45 мянган төгрөгийг чанаргүй зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна. Тайлант хугацаанд хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн 15,303,591.94 мянган төгрөгийн үлдэгдэлд 30.5 хувь буюу 4,672,846.82 мянган төгрөгийн зээлийн эрсдэлийн санг байгуулсан байна. Зээлдэгчдийн мэдээллийг зээлийн чанараар ангилахад нийт зээлдэгчийн 92.4 хувийг хэвийн, 3.3 хувийг хугацаа хэтэрсэн, 4.3 хувийг чанаргүй зээлдэгч эзэлж байна. Чанаргүй зээлийн үлдэгдэлтэй 1,306 зээлдэгчийн 7,269,514.45 мянган төгрөгийн үлдэгдлийн 26.4 хувийг

хэвийн бус, 34.4 хувийг эргэлзээтэй, 39.2 хувийг муу зээлийн үлдэгдэлтэй зээлдэгчид тус тус эзэлж байна.

Тайлант улиралд нийт зээлд эзлэх хэвийн зээлийн хувь хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.0 пунктээр буурч 93.1 хувь, хугацаа хэтэрсэн зээлийн хувь хэмжээ 1.1 пунктээр нэмэгдэж 3.6 хувьд хүрсэн байна.

График 7: Зээлийн чанар



Хүснэгт 13: Зээлийн ангиллын мэдээлэл хот, орон нутгаар /мянган төгрөгөөр/


Зээлийн ангиллын мэдээлэл	Улаанбаатар хот			Орон нутаг		
	Дүн	Хувь	Нийт дүнд эзлэх хувь	Дүн	Хувь	Нийт дүнд эзлэх хувь
Нийт	170,395,599.16	100.0%	77.3%	50,008,483.58	100.0%	22.7%
Хэвийн	157,702,378.28	92.5%	76.9%	47,398,112.52	94.8%	23.1%
Хугацаа хэтэрсэн	6,425,256.81	3.8%	80.0%	1,608,820.68	3.2%	20.0%
Чанаргүй	6,267,964.07	3.7%	86.2%	1,001,550.38	2.0%	13.8%
<i>Хэвийн бус</i>	<i>1,380,441.43</i>	<i>22.0%</i>	<i>71.9%</i>	<i>538,277.70</i>	<i>53.8%</i>	<i>28.1%</i>
<i>Эргэлзээтэй</i>	<i>2,293,418.50</i>	<i>36.6%</i>	<i>91.8%</i>	<i>204,562.92</i>	<i>20.4%</i>	<i>8.2%</i>
<i>Муу</i>	<i>2,594,104.15</i>	<i>41.4%</i>	<i>90.9%</i>	<i>258,709.76</i>	<i>25.8%</i>	<i>9.1%</i>

Зээлийн ангиллын мэдээллийг хот, орон нутгаар ангилан харвал ХЗХ-ны зах зээлийн нийт зээлийн 77.3 хувь буюу 170,395,599.16 мянган төгрөгийг Улаанбаатар хотын ХЗХ-д, 22.7 хувь буюу 50,008,483.58 мянган

төгрөгийг орон нутгийн ХЗХ-дын зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна. Улаанбаатар хотын ХЗХ-дын зээлийн үлдэгдлийн 92.5 хувь буюу 157,702,378.28 мянган төгрөгийг хэвийн, 3.8 хувь буюу 6,425,256.81 мянган

төгрөгийг хугацаа хэтэрсэн, 3.7 хувь буюу 6,267,964.07 мянган төгрөгийг чанаргүй зээлийн үлдэгдэл эзэлж байна. Чанаргүй зээлийн үлдэгдлийн 41.4 хувь буюу 2,594,104.15 мянган төгрөгийг муу зээлийн үлдэгдэл бүрдүүлж байгаа бөгөөд зах зээлийн нийт муу зээлийн 90.9 хувийг эзэлж байна. Орон нутгийн ХЗХ-дын зээлийн үлдэгдлийн 94.8 хувь буюу 47,398,112.52 мянган төгрөгийг хэвийн, 3.2 хувь буюу 1,608,820.68 мянган төгрөгийг хугацаа хэтэрсэн, 2.0 хувь буюу 1,001,550.38 мянган төгрөгийг чанаргүй зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна.

График 8: Зээлийн багцын чанар /тэрбум төгрөгөөр/



Хүснэгт 14: Зээлийн бүтээгдэхүүнээр /мянган төгрөгөөр/

№	ЗЭЭЛИЙН ЗОРИУЛАЛТ	Зээлийн эхний үлдэгдэл /дүн/	Тайлант хугацаанд олгосон зээл	Тайлант хугацаанд эргэн төлөгдсөн зээл	Зээлийн эцсийн үлдэгдэл	Зээлийн үлдэгдлийн нийт зээлд эзлэх хувь
1	Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	9,166,315.80	9,010,737.68	8,391,398.10	9,785,655.38	4.4%
2	Уул уурхай, олборлолт	1,551,211.81	902,093.99	874,526.52	1,578,779.28	0.7%
3	Боловсруулах үйлдвэрлэл	1,356,324.76	375,816.80	707,880.90	1,024,260.67	0.5%
4	Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	436,421.53	342,222.20	370,685.47	407,958.27	0.2%
5	Усан хангамж, бохир ус, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	1,820,732.49	1,839,049.10	1,700,646.19	1,959,135.40	0.9%
6	Барилга	6,485,154.74	4,668,792.15	3,088,056.66	8,065,890.23	3.7%
7	Бөөний болон жижиглэн худалдаа	16,766,201.29	52,652,077.17	51,162,885.99	18,255,392.48	8.3%
8	Машин мотоциклийн засвар үйлчилгээ	5,196,021.15	45,985,641.83	46,756,767.51	4,424,895.48	2.0%
9	Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	6,237,462.08	19,594,155.20	21,128,552.61	4,703,064.67	2.1%
10	Байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	3,964,829.98	9,410,998.60	2,937,932.01	10,437,896.56	4.7%
11	Мэдээлэл холбоо	4,992,452.23	678,960.00	683,265.06	4,988,147.17	2.3%
12	Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	19,207,818.45	7,980,500.00	3,717,326.81	23,470,991.64	10.6%
13	Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	910,930.63	354,958.69	383,440.45	882,448.86	0.4%
14	Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	640,879.42	250,800.00	239,888.98	651,790.43	0.3%
15	Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	348,195.96	118,006.00	143,319.71	322,882.25	0.1%
